



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 04 дүгээр сарын 05 өдөр Дугаар 08

Хэрлэн сум

VIII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 08 дугаар хуралдаан 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 14:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд цомхотгосон хэлбэрээр 52,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ш.Ёл даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1. Мал эмнэлгийн газраас аймгийн Онцгой комисст ирүүлсэн “Хорио цээрийн дэглэм цуцлах санал хүргүүлэх тухай” 97 дугаар албан бичиг танилцуулах,  
*Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар  
Мал эмнэлгийн газар*

2. “Хорио цээрийн дэглэм цуцлах тухай” аймгийн Засаг даргын захирамжийн төсөл танилцуулах,  
*Мал эмнэлгийн газар*


ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Аюушмаа-д:

1.1. Малын шинжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллах тухай сумын Онцгой комисст аймгийн Онцгой комиссоос албан бичгээр үүрэг чиглэл өгч ажиллах,  
1.2. “Хорио цээрийн дэглэм цуцлах тухай” аймгийн Засаг даргын захирамжийн төсөлд гишүүдийн саналыг тусгаж батлуулах,

Гаалийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Б.Гэрэлт-Од-д:

1.3. ОХУ-ын Өвөр байгалийн хязгаар нутаг дэвсгэрт малын гоц халдварт боомт өвчний тохиолдол гарсан холбогдуулан хилийн боомтоор нэвтэрч буй тээврийн хэрэгсэлд ариутгал, халдваргүйтгэл хийж ажиллах,

  
Ш.Ёл  
Х/ч Б.Цогтбаяр

Аймгийн Онцгой комиссын нийт гишүүд-д:

1.4.Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хяналтын цэгт аймгийн Онцгой комиссын гишүүд хуваарийн дагуу өдөр бүр хяналт тавьж ажиллахыг тус тус үүрэг болгов.

ОРЛОГЧ ДАРГА

Ш.ЁЛ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
ХОШУУЧ

Б.ЦОГТБАЯР

